

АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



ᠠᠷᠬᠠᠩᠭ᠋ᠠᠢ ᠠᠶᠢᠮᠠᠭ ᠳᠠᠬᠤ ᠲᠥᠷᠢᠶᠢᠨ ᠠᠭᠤᠳᠢᠲᠤ ᠭᠠᠰᠠᠷ

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ЖИЖИГ, ДУНД ҮЙЛДВЭРЛЭЛИЙГ ХӨГЖҮҮЛЭХ САНГИЙН ХӨРӨНГИЙГ
ЗОРИУЛАЛТЫН ДАГУУ ҮР ДҮНТЭЙ ЗАРЦУУЛСАН БАЙНА.

АУДИТЫН НЭР: АРХАНГАЙ АЙМГИЙН ЖИЖИГ, ДУНД ҮЙЛДВЭРЛЭЛИЙГ ХӨГЖҮҮЛЭХ САНГИЙН
2019-2020 ОНЫ ЗЭЭЛИЙН ҮР ДҮН, ЭРГЭН ТӨЛӨЛТИЙН БАЙДАЛ

АУДИТЫН КОД:
АРА-2021/50/-ШТА-ГА



ЦЭЦЭРЛЭГ ХОТ
2021 ОН

Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын дарга
бөгөөд Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа

Утас: 7033-3141 Цахим хаяг: baigalmaat@audit.gov.mn

Аудитын менежер Д.Нэргүйбаатар

Утас: 7033-2860 Цахим хаяг: nerguibaatard@audit.gov.mn

Аудитор П.Энхжаргал

Цахим хаяг: enkhjargalp@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хуудас: www.audit.mn

АГУУЛГА

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, СТАНДАРТ, АРГА ЗҮЙ

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

БҮЛЭГ 1. ЖИЖИГ ДУНД ҮЙЛДВЭРИЙГ ХӨГЖҮҮЛЭХ САНГААС ХӨНГӨЛӨЛТТЭЙ ЗЭЭЛ ОЛГОСОН ТӨСЛИЙН СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫГ ЖУРМЫН ДАГУУ ЯВУУЛСАН БАЙНА.

ЖИЖИГ ДУНД ҮЙЛДВЭР ХӨГЖҮҮЛЭХ ТӨСӨЛ СОНГОН ШАЛГАРУУЛАХ ДЭД ХОРООГ ЖУРМЫН ДАГУУ БАЙГУУЛЖЭЭ.

ЖИЖИГ ДУНД ҮЙЛДВЭРИЙН ТӨСӨЛ ХӨТӨЛБӨРИЙГ ХҮЛЭЭН АВАХ ЗАРЫГ ОРОН НУТГИЙН ОЛОН НИЙТИЙН МЭДЭЭЛЛИЙН ХЭРЭГСЛЭЭР ИРГЭН, АЖ АХУЙН НЭГЖҮҮДЭД ХҮРГЭСЭН БАЙНА.

ДЭД ХОРОО БАТЛАГДСАН ЖУРАМ, ХХААХҮС-ААС ИРҮҮЛСЭН ЧИГЛЭЛИЙН ДАГУУ СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫГ ЯВУУЛСАН БАЙНА.

БҮЛЭГ 2. ЖИЖИГ ДУНД ҮЙЛДВЭРИЙГ ХӨГЖҮҮЛЭХ САНГААС ЗЭЭЛ АВСАН ЗЭЭЛДЭГЧИД ТӨСӨЛД ЗААГДСАН АРГА ХЭМЖЭЭГ ХЭРЭГЖҮҮЛЖ, ЗЭЭЛИЙГ ЗОРИУЛАЛТЫН ДАГУУ ЗАРЦУУЛСАН БАЙНА.

ЖДҮХС-ААС 2019-2020 ОНД АЙМАГТ ХУВААРИЛСАН 2,000.0 СЯ ТӨГРӨГИЙН САНХҮҮЖИЛТЭЭС 1,500.0 СЯ ТӨГРӨГИЙН ЗЭЭЛ ОЛГОСОН БАЙНА.

ЖДҮХС-ААС 2019-2020 ОНД ОЛГОСОН ХӨНГӨЛӨЛТТЭЙ ЗЭЭЛИЙГ ТҮҮВЭРЛЭН ШАЛГАХАД ЗОРИУЛАЛТЫН ДАГУУ ЗАРЦУУЛСАН БАЙНА.

ТӨСӨЛ ХЭРЭГЖСЭНЭЭР ШИНЭЭР БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛЧИЛГЭЭ БИЙ БОЛСОН Ч АЖЛЫН БАЙРЫГ ТӨСӨЛД ЗААГДСАН ХЭМЖЭЭНД НЭМЭГДҮҮЛЭЭГҮЙ БАЙНА.

БҮЛЭГ 3. ӨМНӨХ АУДИТААР ӨГСӨН ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ ХАНГАЛТГҮЙ БАЙНА.

ӨМНӨХ АУДИТААР ӨГСӨН ЗӨВЛӨМЖИЙГ ХЭРЭГЖҮҮЛЖ АЖИЛЛААГҮЙ БАЙНА.

ТӨСӨЛД ХАМРАГДСАН ИРГЭН, ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ЗЭЭЛ АШИГЛАЛТЫН БАЙДАЛД АЙМГИЙН ХХААГ-ААС ХЯНАЛТ ХЭРЭГЖҮҮЛСЭН ЭСЭХ НЬ ТОДОРХОЙГҮЙ БАЙНА.

АУДИТЫН ДҮГНЭЛТ

АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛД ӨГСӨН ТАЙЛБАР

ТАЙЛАН БАТАЛСАН ТУШААЛ

Товчилсон үгийн жагсаалт

ААН	Аж ахуйн нэгж
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ЖДҮХС	Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан
ЖДҮ	Жижиг дунд үйлдвэр
ЖДХҮАҮ	Жижиг, дунд, хөнгөн үйлдвэр, ахуй үйлчилгээ
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
НД	Нийгмийн даатгал
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ХХААХҮЯ	Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яам
ХХААХҮС	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд
ХХААГ	Хүнс, хөдөө аж ахуйн газар
ХХҮГ	Хөдөлмөр халамж үйлчилгээний газар
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХЭДС	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан
СХС	Сум хөгжүүлэх сан

Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх**Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүй**

Аудитыг Монгол Улсын Ерөнхий аудиторын "Аудитын төлөвлөгөө батлах тухай" 2021 оны А/28 тоот тушаалаар батлагдсан аудитын сэдвийн төлөвлөгөө, 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө, Аймгийн ИТХ-ын захиалгыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 6.3.3-т заасан бүрэн эрхийн хүрээнд хийж гүйцэтгэв.

Аудитын зорилт

Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас Архангай аймагт олгосон хөнгөлөлттэй зээлийн зарцуулалт, үр дүн, эргэн төлөлтийн байдалд аудит хийж, зээлийг үр ашигтай зарцуулсан эсэх, төслийн зорилго, зорилтыг хангаж үр дүнд хүрсэн эсэхэд дүгнэлт гарган, дүнг аймгийн ИТХ, Засаг дарга, ХХААГ-т танилцуулах, цаашид зээлийн ашиглалтыг сайжруулах, үр өгөөжийг дээшлүүлэх талаар хэрэгжүүлэх боломжит арга хэмжээг авч бодит үр дүнд хүрэхэд аудитын зорилт чиглэгдлээ. Дээрх зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудитыг гүйцэтгэв. Үүнд:

1. Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас олгосон хөнгөлөлттэй зээлийн төслийн сонгон шалгаруулалтыг журмын дагуу явуулсан эсэх
2. Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас олгосон хөнгөлөлттэй зээлийг зориулалтын дагуу зарцуулж, үр дүн гарсан эсэх
3. Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж, хяналт тавьж ажилласан эсэх

Аудитын хамарсан хүрээ

Аудитад Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас 2019-2020 онд олгосон хөнгөлөлттэй зээлийг хамруулан гүйцэтгэлээ.

Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитыг гүйцэтгэхэд АДБОУС 300, 3000-д нийцүүлэн баталсан Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-1:2020 "Төрийн аудит, тулгуур зарчим", MNS 6817-5:2020 "Төрийн аудит, гүйцэтгэлийн аудитын тулгуур зарчим", "Төрийн аудит, гүйцэтгэлийн аудит" стандартад үндэслэн боловсруулсан гүйцэтгэлийн аудитын заавар, аргачлалд заасан арга зүйг ашиглан Тэргүүлэх аудиторын баталсан төлөвлөгөө, хөтөлбөрийг мөрдлөг болгон холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга авах, мэдээ тайлан, судалгаанд тулгуурлан дүн шинжилгээ хийж, аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээний дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

**Аудитын бүрэлдэхүүн,
хугацаа**

Аудитыг Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа хянан удирдаж, аудитын менежер Д.Нэргүйбаатар чанарын хяналтыг хэрэгжүүлж, аудитор П.Энхжаргал, Г.Цог-Эрдэнэ нар гүйцэтгэв. Аудитын нээлтийг 2021 оны 09 дугаар сарын 02-ны өдөр хийж, зээлдэгчийн зээл ашиглалт, үйл ажиллагааг шалгах ажлыг 2021 оны 09 дугаар сарын 02-ны өдрөөс эхлэн, аудитын тайланг холбогдох үе шатны хяналтаар хянуулан, тайланг 2021 оны 10 дугаар сарын 20-ны өдөр ИТХ-ын дарга, аймгийн Засаг дарга, ХХААГ-т хүргүүлж ажиллав.

Хүндрэл бэрхшээл

- ЖДҮХС-аас арилжааны банкаар дамжуулан зээл авсан зээлдэгч нарын зээлийн зарцуулалтыг шалгахад зээлийн хөрөнгөөр эргэлтийн болон үндсэн хөрөнгө авахдаа нэхэмжлэх, орлого, зарлагын баримтгүй нь зээлдэгчийн ашиглаж байгаа тоног төхөөрөмжийг шинээр худалдан авсан эсэхийг нягтлах боломжгүй байв.
- Мөн дэлхий нийтийг хамарсан цар тахлын үед бизнесийн салбаруудын дийлэнх нь үйл ажиллагаагаа зогсоосон байв.

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас 2019-2020 онд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын /цаашид ХХААХҮС гэх/ 2019 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн А/41 дүгээр, 2020 оны 04 дугаар сарын 17-ны өдрийн А/131 дүгээр тушаалуудаар ЖДҮХС-аас Архангай аймагт 2019-2020 онд тус бүр **нэг тэрбум** төгрөг хуваарилсан байна.

Аймгийн Засаг даргын 2019 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн А/360 дугаар, 2020 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн А/264 дугаар захирамжаар аймгийн Засаг даргын тамгын газрын даргаар ахлуулсан 8 хүний бүрэлдэхүүнтэй аймгийн жижиг дунд үйлдвэрийн /цаашид ЖДҮ гэх/-ийн төслийг сонгон шалгаруулж, шийдвэр гаргах чиг үүрэг бүхий, хяналт тавих дэд хороог томилжээ. Дэд хороо 2019 онд иргэд, хуулийн этгээдээс нийт 32 төслийг хүлээн авснаас журамд заасан зээлийн доод хэмжээнээс доогуур 8 төслийг хасаж, 2019 оны 07 дугаар сарын 26-ны өдөр 24 төслийг хэлэлцэж, тэргүүн ээлжинд санхүүжүүлэх нэг тэрбум төгрөгийн 24 төслийг дэмжин, аймгийн Засаг даргад албан бичиг хүргүүлсэн байна.

Хүснэгт 1. ЖДҮХС-гаас зээл авахаар санал ирүүлсэн, дэмжигдсэн төслийн судалгаа

Ангилал	Ирүүлсэн төсөл		Дэд хорооноос шалгаруулсан төсөл		Банк болон сангийн шаардлагад нийцэж, санхүүжилт олгосон төсөл	
	2019 он	2020 он	2019 он	2020 он	2019 он	2020 он
Иргэн	35		12		9	
Аж ахуйн нэгж	25	32	12	15	11	5
Нийт	60	32	24	15	20	5

ЖДҮХС-аас хөнгөлөлттэй зээл авсан 25 иргэн, аж ахуйн нэгжийн судалгааг Хавсралт 1-т харуулав.

Аймгийн Засаг даргаас 2019 оны 07 дугаар сарын 26-ны өдөр ЖДҮХС болон орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа арилжааны банкнуудад албан бичиг хүргүүлсэн ба дэд хороогоор дэмжигдсэн 24 төслөөс арилжааны банкны тавьсан шаардлагыг хангасан 20

иргэн, аж ахуйн нэгжид нийт нэг тэрбум төгрөгийг Хаан банкаар олгож, аймагт батлагдсан нэг тэрбум төгрөгийн санхүүжилтийг бүрэн ашигласан байна. Харин 2020онд ЖДҮХС-нд аймгийн дэд хороогоор дэмжигдсэн 15 төслийг битүүмжлэн хүргүүлснээс ЖДҮДС-ийн шаардлагыг хангаагүй 10 төсөл хасагдаж, шаардлагыг хангасан 5 төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгжид нийт 500.0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг олгосон байна.

ХХААХҮС-ын 2019.05.14-ний өдрийн А/146 дугаар тушаалаар хөнгөлөлттэй зээлийн ерөнхий нөхцөлийг баталсан ба арилжааны банкаар дамжуулан олгох зээлийн хүүг 8 хувиас ихгүй байх, 5 хүртэл жилийн хугацаатай олгож, үндсэн зээлээс эхний 12 сарын хугацаанд чөлөөлөхөөр заасны дагуу Хаан банк 5.4%-ийн хүүтэй, 60 сарын хугацаатай олгосон байна.

Эрдэнэбулган, Ихтамир, Тариат, Цэнхэр сумдад үйл ажиллагаа явуулж байгаа 19 зээлдэгч нарын үйл ажиллагааг аудитын явцад шалгахад 18 зээлдэгчийн үйл ажиллагаа хэвийн явагдаж, орон нутагт импортыг орлох бүтээгдэхүүнийг үйлдвэрлэж байна.

Орон нутгийн онцлог, нөөцөд суурилан дэвшилтэт техник, технологи нэвтрүүлж, нэмүү өртөг шингэсэн, олон улсын чанар, стандартын шаардлага хангасан, өрсөлдөх чадвартай зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцсэн, тогтвортой үйлдвэрлэлийг хөгжүүлж, ажлын байр, гадаад, дотоод худалдааны эргэлт, эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлэх зорилгоор Засгийн газрын 2018 оны 36 дугаар тогтоолоор “Үйлдвэржилт 21:100” (2018-2021) үндэсний хөтөлбөрийг баталсан ба аймгийн хөгжлийн бодлого төлөвлөлттэй уялдуулан ЖДҮХС-аас зээл олгох салбарыг тодорхойлжээ.

Монгол улсын Засгийн газрын 2018 оны 36 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Үйлдвэржилт 21:100” үндэсний хөтөлбөр (2018-2021)-т Архангай аймагт борц үйлдвэрлэх, жимс, жимсгэнэ боловсруулах, бетон зуурмаг үйлдвэрлэх, сүү, сүүн бүтээгдэхүүн, цөцгийн тос, ээдэмцэрийн үйлдвэр гэсэн 4 үйлдвэрийг байгуулахаар тусгажээ.

БҮЛЭГ 1. ЖИЖИГ ДУНД ҮЙЛДВЭРИЙГ ХӨГЖҮҮЛЭХ САНГААС ХӨНГӨЛӨЛТТЭЙ ЗЭЭЛ ОЛГОСОН ТӨСЛИЙН СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫГ ЖУРМЫН ДАГУУ ЯВУУЛСАН БАЙНА.

ЖИЖИГ ДУНД ҮЙЛДВЭР ХӨГЖҮҮЛЭХ ТӨСӨЛ СОНГОН ШАЛГАРУУЛАХ ДЭД ХОРООГ ЖУРМЫН ДАГУУ 8 ХҮНИЙ БҮРЭЛДЭХҮҮНТЭЙ БАЙГУУЛЖЭЭ.

1.1. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2019 оны А/119 дүгээр тушаалаар батлагдсан “Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас урт хугацаатай, хөнгөлөлттэй зээл олгох, төсөл сонгон шалгаруулах журам”-ын /цаашид журам гэх/ 6.8¹-т заасны дагуу аймгийн Засаг даргын 2019 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн А/360 дугаар, 2020 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн А/264 дугаар захирамжаар аймгийн жижиг дунд үйлдвэрийн /цаашид ЖДҮ гэх/-ийн төслийг сонгон шалгаруулж, шийдвэр гаргах чиг үүрэг бүхий, хяналт тавих дэд хороог томилсон байна.

1.2. Журмын 6.1², 6.2³ -т заасны дагуу дэд хороог 8 хүний бүрэлдэхүүнтэй байгуулж, дэд хорооны даргаар аймгийн Засаг даргын тамгын дарга, нарийн бичгээр аймгийн ХХААГ-ын жижиг, дунд үйлдвэрийн асуудал хариуцсан мэргэжилтэн, гишүүдээр аймгийн ХХААГ-ын дарга, аймгийн Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газрын дарга нар болон төрийн бус байгууллагуудын төлөөллийг журмын 6.3⁴-т заалтын дагуу томилсон байна.

Аймгийн дэд хорооны бүрэлдэхүүнд:

Дэд хорооны дарга: Б.Цэрэннадмид /аймгийн ЗДТГ-ын дарга/

Гишүүдэд: П.Гомбодорж /ХХААГ-ын дарга/

Д.Мөнхбат /ХХҮГ-ын дарга/

Г.Чулуунбаатар /Хөдөө аж ахуй хоршоологчдын холбооны дарга/

И.Ням-Осор /Аймгийн хүнсчдийн холбооны дарга/

Б.Цолмонбаяр / Жижиг, дунд үйлдвэр, эрхлэгчдийн холбооны Удирдах зөвлөлийн дарга/

Т.Хонгорзул / Мэдлэгийн сүлжээ ТББ тэргүүн/

Нарийн бичгийн дарга: Ц.Санжидмоллом / ХХААГ-ын жижиг, дунд үйлдвэрлэл хариуцсан мэргэжилтэн/

ЖИЖИГ ДУНД ҮЙЛДВЭРИЙН ТӨСӨЛ ХӨТӨЛБӨРИЙГ ХҮЛЭЭН АВАХ ЗАРЫГ ОРОН НУТГИЙН ОЛОН НИЙТИЙН МЭДЭЭЛЛИЙН ХЭРЭГСЛЭЭР ИРГЭН, АЖ АХУЙН НЭГЖҮҮДЭД ХҮРГЭСЭН БАЙНА.

1.3. Төсөл хүлээн авах зарыг “Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас урт хугацаатай, хөнгөлөлттэй зээл олгох, төсөл сонгон шалгаруулах журам”-ын 10.4⁵, ХХААХҮЯ-ны 2019.05.16-ны өдрийн 01/1930 дугаар, 2020.04.16-ны өдрийн 01/1456 дугаар албан бичгээр ирүүлсэн чиглэлийн дагуу 2019 онд журмын дагуу 14 хоногийн өмнө орон нутгийн “АВ”

¹ Хорооны бүрэлдэхүүнийг Жижиг, дунд үйлдвэрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, дэд хорооны бүрэлдэхүүнийг аймгийн Засаг дарга тус тус батална

² Хороо, дэд хороо нь дарга, гишүүд, нарийн бичгийн даргаас бүрдсэн найман хүний бүрэлдэхүүнтэй байна.

³ Дэд хорооны бүрэлдэхүүнд аймгийн жижиг, дунд үйлдвэрийн асуудал хариуцсан байгууллагын дарга болон аймгийн хөдөлмөр, халамжийн хэлтсийн төлөөлөл орох бөгөөд нарийн бичгийн даргаар аймгийн жижиг, дунд үйлдвэрийн асуудал хариуцсан байгууллагын жижиг, дунд үйлдвэрийн асуудал хариуцсан мэргэжилтэн /цаашид аймгийн мэргэжилтэн гэх/ байна.

⁴ Төлөөлөл оролцуулах төрийн бус байгууллага, мэргэжлийн байгууллагыг нээлттэй сонгон шалгаруулах бөгөөд жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдийн эрх ашгийг хамгаалах чиглэлээр сүүлийн 3 жил үйл ажиллагаа явуулсан байна.

⁵ Сан, аймгийн жижиг, дунд үйлдвэрийн асуудал хариуцсан байгууллага нь төсөл хүлээн авахаас хуанлийн 10-аас доошгүй хоногийн өмнө олон нийтийн хэвлэл, мэдээллийн хэрэгслээр зарлана. Төслийг хуанлийн 14 хоногийн турш хүлээн авна.

телевиз, “Архангайн толь” сониноор иргэд, олон нийтэд нээлттэй мэдээлсэн байна. Харин Монгол улсын засгийн газрын 2020 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн 113 дугаар тогтоолоор баталсан журмын 10.5⁶ -т заасны дагуу 30 хоногийн өмнө орон нутгийн “АВ” телевиз, “Архангайн толь” сониноор иргэд, олон нийтэд нээлттэй мэдээлжээ.

1.4. Орон нутгийн “АВ”, “Тамир” телевизүүдээр, “Архангай толь” сонин, мөн өөрсдийн бэлтгэж иргэд, олон нийтэд таарсан боршур зэрэг төсөл хүлээн авах зар бүхий материалд “Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас урт хугацаатай, хөнгөлөлттэй зээл олгох, төсөл сонгон шалгаруулах журам”-ын 10.2⁷ -т заасан төсөл авч эхлэх хугацаа, дуусах хугацаа, байршил, зээлийн нөхцөл, холбоо барих утасны дугаарыг тодорхой бичсэн байна.

ДЭД ХОРОО БАТЛАГДСАН ЖУРАМ, ХХААХҮС-ААС ИРҮҮЛСЭН ЧИГЛЭЛИЙН ДАГУУ СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫГ ЯВУУЛСАН БАЙНА.

1.5. Төсөл сонгон шалгаруулах дэд хороо нь ХХААХҮС-ын ирүүлсэн чиглэлийн дагуу ЖДҮ-ийг хөгжүүлэх тэргүүлэх чиглэлийг баримталж, сонгон шалгаруулсан байна. Харин хөнгөлөлттэй зээл олгох шийдвэрийг гаргахад оролцох эрх бүхий этгээд нь ашиг сонирхлын зөрчлөөс ангид байж, нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасан мэдэгдэл, тайлбарыг тухай бүр гаргаж ажиллаагүй байна. Иймд аудитаас ашиг сонирхолын зөрчилгүй мэдэгдлийг тухай бүр хөтөлж, баримтжуулж байх зөвлөмжийг ХХААГ-т хүргүүлэв.

2020 онд орон нутагт зээл хүсэгчээс ирүүлсэн баримт, материал, сонгон шалгаруулалттай холбогдох баримт материалуудыг ЖДҮХС-нд шилжүүлсэн нь ЖДҮ эрхлэгчийн төслийн хүрэх үр дүн, шаардлага хангасан төслийг сонгон шалгаруулсан эсэхэд дүгнэлт өгөх боломжгүй байна.

1.6. Аймгийн ИТХ-аас аймгийг хөгжүүлэх тэргүүлэх чиглэлийг батлаагүй байна. (Эх сурвалж: аймгийн ИТХ-ын 2021 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн 113 тоот албан бичиг) Үүний улмаас төсөл шалгаруулах дэд хороо нь ХХААХҮЯ-ны 2019.05.16-ны өдрийн 01/1930 тоот албан бичгээр аймгийн ХХААГ-ын даргад ирүүлсэн чиглэлийг хэрэгжүүлэх боломжгүй болсон байна.

- Иймээс Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн дагуу аймгийг хөгжүүлэх тэргүүлэх чиглэлийг баталж ажиллах зөвлөмжийг Аймгийн ИТХ-ын даргад хүргүүлэв.

⁶ Жижиг, дунд үйлдвэрийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага болон аймаг, нийслэлийн жижиг, дунд үйлдвэрийн асуудал хариуцсан байгууллага нь төсөл хүлээн авах хугацааг олон нийтийн хэвлэл, мэдээллийн хэрэгслээр зарлаж, тухайн өдрөөс хойш хуанлийн 30 хоногийн хугацаанд цахимаар эсхүл цаасан хэлбэрээр хүлээн авна. (Энэ заалтад Засгийн газрын 2020 оны 251 дүгээр тогтоолоор өөрчлөлт орсон)

⁷ Жижиг, дунд үйлдвэрийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага улсын хэмжээнд төсөл хүлээн авах зарыг өдөр тутмын мэдээллийн хэрэгслээр олон нийтэд мэдээлэх үүргийг хүлээнэ. аймаг, нийслэлийн жижиг, дунд үйлдвэрийн асуудал хариуцсан байгууллага нь энэхүү зарыг тухайн орон нутагт мэдээлэх үүргийг хүлээнэ. Төсөл хүлээн авах зард төсөл хүлээн авч эхлэх, дуусах хугацаа, байршил, цахим хаяг, зээлийн нөхцөл, холбоо барих утасны дугаар зэрэг мэдээллийг тусгасан байна. (Энэ заалтад Засгийн газрын 2020 оны 251 дүгээр тогтоолоор өөрчлөлт орсон)

БҮЛЭГ 2. ЖИЖИГ ДУНД ҮЙЛДВЭРИЙГ ХӨГЖҮҮЛЭХ САНГААС ЗЭЭЛ АВСАН ЗЭЭЛДЭГЧИД ТӨСӨЛД ЗААГДСАН АРГА ХЭМЖЭЭГ ХЭРЭГЖҮҮЛЖ, ЗЭЭЛИЙГ ЗОРИУЛАЛТЫН ДАГУУ ЗАРЦУУЛСАН БАЙНА.

ЖДҮХС-ААС 2019-2020 ОНД АЙМАГТ ХУВААРИЛСАН НИЙТ ХОЁР ТЭРБУМ ТӨГРӨГИЙН САНХҮҮЖИЛТЭЭС 1,500.0 САЯ ТӨГРӨГИЙН ЗЭЭЛ ОЛГОСОН БАЙНА.

2.1. Аймгийн ХХААГ нь журамд заасан хугацаанд 2019 онд 37 иргэн, 23 аж ахуйн нэгжийн нийт 4,279.9 сая төгрөгийн 60 төсөл, 2020 онд 32 аж ахуйн нэгжийн нийт 3,972.7 сая төгрөгийн 32 төсөл хүлээн авсан байна. Аймгийн Засаг даргаас 2019 оны 07 дугаар сарын 26-ны өдөр ЖДҮХС болон орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа арилжааны банкуудад албан бичиг хүргүүлсэн ба дэд хороогоор дэмжигдсэн 24 төслөөс арилжааны банкнаас тавьсан шаардлагыг хангасан 20 иргэн, аж ахуйн нэгжид нийт нэг тэрбум төгрөгийг ХААН банкаар олгож, аймагт батлагдсан санхүүжилтийг бүрэн ашигласан байна. Харин 2020 онд ЖДҮХС-нд дэд хороогоор дэмжигдсэн 15 төслөөс шаардлага хангасан 5 аж ахуйн нэгжид нийт 500.0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг олгож, бусад зээл хүсэгч нь шаардлага хангаагүйн улмаас аймагт батлагдсан 500.0 сая төгрөгийн санхүүжилтийг ашиглах боломжийг алдсан байна.

2.2. ХХААГ-ын жижиг, дунд үйлдвэрлэл хариуцсан мэргэжилтэн нь Монгол банкны мэдээллийн санд /тариалан эрхлэлтийг дэмжих сан, мал хамгаалах сан, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан, сум хөгжүүлэх сан/ гэх зэрэгт зээлийн үлдэгдэлтэй, муу зээлийн түүхтэй иргэн, аж ахуйн нэгжийн мэдээллийг авч тулган шалгадаг учраас зөрчилтэй иргэн, аж ахуйн нэгжүүдийг зээлд хамруулаагүй байна. ХХААГ-ын мэргэжилтэн ирүүлсэн төслийг төсөл бүртгэх <http://office.smefund.gov.mn> бүртгэлийн нэгдсэн санд мэдээлсэн байна.

ЖДҮХС-ААС 2019-2020 ОНД ОЛГОСОН ХӨНГӨЛӨЛТТЭЙ ЗЭЭЛИЙГ ЗОРИУЛАЛТЫН ДАГУУ ЗАРЦУУЛСАН БАЙНА.

2.3. Аймгийн ЖДҮХС Аймгийн ЗДТГ-ын даргаар ахлуулсан дэд хороо гишүүдийн 100 хувийн ирцтэйгээр хуралдаж, зээл хүссэн 92 төслийн иж бүрдлийг шалгах хуудсаар шалгаж, 45 төслийг шаардлага хангахгүй гэж үзэн буцаасан байна. Тус хурлаар ХХААХҮ-ийн сайдын 2019.05.14-ний өдрийн А/146 дугаар тушаалаар баталсан салбарын жагсаалтад ороогүй нийтийн хоолны газар, тээвэр үйлчилгээ, дулаан үйлдвэрлэл, эрүүл мэндийн үйлчилгээний төслийг дэмжих боломжгүй гэж шийдвэрлэсэн байна. Харин 2019 онд ЖДҮХС-аас зээл авсан иргэн Б.Янжинлхамд "Өдөр тутмын болон гоёлын хувцас үйлдвэрлэл" төсөлд олгосон 30.0 сая төгрөгийн зээл нь орон нутагтаа үйл ажиллагаа явуулаагүй, төлөвлөсөн ажлын байрыг бий болгосон нь тодорхойгүй байгаад ХХААГ-аас хяналт тавьж ажиллаагүй байна.

- Иймд аудитаас алдаа зөрчлийг таслан зогсоож, цаашид давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

Аудитад хамруулсан төслүүдийн хэрэгжилтийн талаар:

"Уламбаяжихуй" ХХК "Өдөр бүр-Шинэ хүнс" төсөл



2019 онд үйлдвэр үйлчилгээний барилга барих 200.0 сая төгрөгийн төсөл ирүүлж, 200.0 сая төгрөгөөр дэмжигдэн зээл авсан Эрдэнэбулган сумын 2-р баг Дэмид жанжины гудамж 1-108 "Фламинго" рестораныг ашиглалтад оруулж, төсөлд тусгагдсан 20 хүнийг ажлын байраар ханган ажиллаж, НДШ-ийг бүрэн төлж байна.

Наймган тал Дэйри ХХК "Цагаан идээний бүрэн автомат үйлдвэр байгуулах" төсөл



2019 онд цагаан идээг олон төрлөөр үйлдвэрлэх тоног төхөөрөмж худалдан авах, түүхий эд худалдан авах 150.0 сая төгрөгийн төсөл ирүүлж, 120.0 сая төгрөгөөр дэмжигдэн зээл авч Эрдэнэбулган сумын 7-р багийн 25-2520 тоотод үйлдвэр үйлчилгээгээ явуулж, төсөлд тусгагдснаар байнгын 4 ажлын байр, түр 9 ажлын байрыг бий болгоод НДШ-ийг төлдөг байна. 2021 онд зээлийн эргэн төлөлт хийгдээгүй учраас аудитаас зөрчлийг таслан зогсоох, давтан гаргахгүй ажиллах, хяналт тавих албан шаардлага хүргүүлж ажиллахаар шийдвэрлэсэн.

"Ар арвижин дэлгэрэх" хоршоо

"Сарлагийн хөөврөн сүлжмэл бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг хөгжүүлэх" төсөл




2019 онд сарлагийн хөөвөр бэлтгэл, экспортод гаргаж байгаа хөөврийн хэмжээг нэмэгдүүлэхээс гадна үйлдвэрлэлийн цехээ өргөтгөх, үйлдвэрийн хүчин чадлийг нэмэгдүүлэх тоног төхөөрөмж худалдан авах, ажлын байр нэмэгдүүлж үйлдвэрлэлээ хөгжүүлэхээр 128.0 сая төгрөгийн төсөл ирүүлж, 62.0 сая төгрөгөөр батлагдаж, зээл авсан "Ар арвижин дэлгэрэх" хоршоо нь сарлагийн хөөврийг боловсруулж эрхэлдэг ба зээлийн хөрөнгийг тоног төхөөрөмж, түүхий эд худалдан авах зардалд зарцуулжээ. Одоогоор байнгын 3 хүнийг

ажлын байраар хангаж НДШ-ийг төлж байна.

"Тайхар Милко" ХХК

Фермерийн үйл ажиллагааг өргөжүүлэн үйлдвэрлэлийн байр шинээр барих



2019 онд үнээний фермерийн үйл ажиллагаандаа зориулж Алатау үүлдрийн сүүний 15 үнээ болон малын өвс, тэжээл, түүхий эд материал худалдан авах зориулалтаар 103.7 сая төгрөгийн төсөл ирүүлж, 50.0 сая төгрөгөөр батлагдсан байна. Төсөлд тусгагдсан санхүүжилтээ авч чадаагүй хэдий ч үнээгээ худалдаж аваад үйл ажиллагаа хэвийн явагдаж байна. Ковид-19 цар тахалтай холбоотойгоор сүү, сүүн бүтээгдэхүүн нийлүүлэхээр гэрээ хийсэн 13 хүүхдийн цэцэрлэг, Их тамир сумын сургууль, цэцэрлэгийн үйл

ажиллагаа нь зогссонтой холбоотой хүндрэл бэрхшээлтэй асуудал тулгарч байна. Одоогийн байдлаар 4 ажлын байр бий болгосон байна.

"Арвижих цэнхэр" ХХК "Аялал жуулчлал" төсөл



2020 онд үйлчилгээний барилга, хашаа барих, ариун цэврийн барилга гүний худаг, шинэ гэр барих 290.0 сая төгрөгийн төсөл ирүүлж, 200.0 сая төгрөгөөр батлагдаж хөнгөлөлттэй зээл авсан байна. Зээлийг зориулалтын дагуу зарцуулж рестораны барилгыг эхлүүлсэн, 10 гэр худалдан авсан, гүний худгийг бүрэн ашиглалтад оруулсан байна. Одоогоор 10 хүнийг ажлын байраар хангаж, НДШ-ийг бүрэн төлж ажилласан байна.

“Хангайн ногоон мандал” ХХК “Архангайн ургац” төсөл



2019 онд хүнсний ногоо тариалах, жимс химсгэнэ худалдаалах 35.0 сая төгрөгийн төсөл ирүүлсэн 20.0 сая төгрөгөөр батлагдаж, хөнгөлөлттэй зээл авсан. Тухайн төсөл хэрэгжүүлэгч нь хүлэмжинд хүнсний ногоо тариалж, хүнсний 3 цэгээр борлуулалтаа хийж үйл ажиллагаа хэвийн явагдаж байна. Төсөл хэрэгжүүлснээр 2 ажлын байр шинээр бий болгож ажиллагсдыг НД-д хамруулсан байна.

Д.Пүрэвжав “Авто засвар” төсөл



2019 онд өргөтгөлийн засвар, тоног төхөөрөмж худалдан авах 30.0 сая төгрөгийн төсөл ирүүлж, 20.0 сая төгрөгөөр батлагдаж, хөнгөлөлттэй зээл авсан. Зээлийг зориулалтын дагуу зарцуулж авто засварыг өргөжүүлж, мөн шаардлагатай тоног төхөөрөмжийг худалдан авсан байна. Төслөөс санхүүжилт авснаар 2 туслах ажилтан ажиллуулж байна.

Б.Эрдэнэбат “Содон шийдэл тавилга үйлдвэрийн” төсөл



2019 онд DCP, UV-PVC, ZIG ZAG хавтан болон модоор гэр ахуйн болон оффисын тавилга хийх 49.0 сая төгрөгийн төсөл ирүүлж, 35.0 сая төгрөгөөр батлагдаж, хөнгөлөлттэй зээлийг авчээ. Төсөл хэрэгжүүлэгч нь Эрдэнэбулган сумын 4-р баг Бор толгой 04-09 тоот тоотод өөрийн байрандаа үйлдвэрлэдэг байна. Төслийн хөрөнгөөр тоног төхөөрөмж, түүхий эд бэлтгэсэн байна. Одоогийн байдлаар 2 хүнийг ажлын байраар ханган ажиллаж байна.

Д.Содномсамбуу “Монгол гутал, гөлөм” төсөл



2019 онд угалзтай, угалзгүй эрэгтэй эмэгтэй хүмүүсийн монгол гутал, эмээлийн гөлөм үйлдвэрлэх 52.5 сая төгрөгийн төсөл ирүүлж, 35.0 сая төгрөгөөр батлагдаж, хөнгөлөлттэй зээл авсан байна. Д.Содномсамбуу нь гэртээ үйлдвэрлэлээ явуулдаг бөгөөд төсөлд хамрагдсанаар оёдлын машин болон булгаар, имжээр гэх мэт түүхий эдийн нөөцийг бэлтгэсэн байна. Төсөл хэрэгжүүлснээр 2 хүнийг түр ажлын байраар хангаж ажиллаж байна.

О.Алтангэрэл "Уламжлалт ааруул цөрөм үйлдвэрлэх" төсөл



2019 онд уламжлалт аргаар цагаан идээ болосруулахаар 80.0 сая төгрөгийн төсөл ирүүлж, 40.0 сая төгрөгөөр батлагдаж хөнгөлөлттэй зээл авсан байна. Төсөлд тусгагдсны дагуу цагаан идээ үйлдвэрлэж хэрэглэгчдийн гар дээр шууд хүргэж байна. Төсөлд тусгагдснаар 3 ажлын байрыг бий болгосон байна.

- Арилжааны банкнууд төслийн зээлийг олгохдоо Монгол банкны мэдээллийн сангаас лавлагаа авч, журмын шаардлага хангасан иргэн, ААН-д хөнгөлөлттэй зээлийг олгосон байна.
- Дэд хороо төсөл ирүүлсэн иргэн, аж ахуйн нэгжийн анх хүссэн зээлийг бууруулж баталснаас санхүүжилт дутагдаж төсөлд заагдсан зориулалтын дагуу зээлийг бүрэн ашиглах боломжгүй болсон гэсэн тайлбарыг ихэнх зээлдэгч нар өгсөн болно.

2.4. Өмнөх онуудад ЖДҮДС-аас олгогдсон 9 төслөөс 3 зээл нь бүрэн хаагдсан үлдсэн 6 төсөл нь 39.9 сая төгрөгийн үлдэгдэлтэй байгаа бөгөөд Ковид-19 цар тахалтай холбоотойгоор гарсан засгийн газрын тогтоолын дагуу зээлийн эргэн төлөлтийг хойшлуулсан байна.

ТӨСӨЛ ХЭРЭГЖСЭНЭЭР ШИНЭЭР БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛЧИЛГЭЭ БИЙ БОЛСОН Ч АЖЛЫН БАЙРЫГ ТӨСӨЛД ЗААГДСАН ХЭМЖЭЭНД НЭМЭГДҮҮЛЭЭГҮЙ БАЙНА.

ЖДҮХС-аас олгосон хөнгөлөлттэй зээлд хамрагдсан 25 иргэн, аж ахуйн нэгжийн хадгалсан болон шинээр бий болгосон ажлын байрыг нийгмийн даатгалын байгууллагад мэдээлж, баталгаажуулсныг тулган шалгахад тухайн зээлдэгчийн ажиллагсдын бодит тоог нотлох боломжгүй байна. Төслийн хүрээнд зээлдэгч нар 116 ажлын байр бий болгохоор төлөвлөсөн ч Ковид-19 цар тахалтай холбоотойгоор шинээр 56 ажлын байрыг бий болгосон байна.

2.5. Энэ нь жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас урт хугацаатай, хөнгөлөлттэй зээл олгох журмын шаардлагыг хангасан зээлдэгч иргэн, аж ахуйн нэгжүүд олон болж, аймаг орон нутагт ажлын байрыг тодорхой хэмжээгээр нэмэгдүүлж байгаа ач холбогдолтой байна.

Төсөлд заагдсан ажлын байрыг нэмэгдүүлж, ажиллагсдын НДШ-ийг төлж байгаа эсэхэд тавих хяналт сул байгаад дүгнэлт хийж, ЖДҮ эрхлэгчдийг санхүүгийн анхан шатны бүртгэл хэрхэн хөтлөх, ажилтан авч ажиллуулахдаа ямар үүрэг хариуцлага ногдох талаарх сургалт явуулж ажиллахыг зөвлөж байна.

ЖДҮХС-аас авсан зээлийг төсөлд заагдсан зориулалтаар зарцуулж, шинээр импортыг орлох бүтээгдэхүүн үйлдвэрлэж, өөрийн болон бусад аймгийн зах зээлд нийлүүлсэн давуу талтай байна. Тухайлбал:

Наймган тал Дэйри ХХК-ны "Цагаан идээний бүрэн автомат үйлдвэр байгуулах" төслийн хүрээнд Архангай аймгийн брэнд бүтээгдэхүүнүүд үйлдвэрлэж, аймгийн лого бүхий бэлгийн багцтай болсон байна. Улаанбаатар хотод болдог үзэсгэлэн худалдаанд аймгийн нэрийн өмнөөс оролцсон байна.

Мөн төсөл хэрэгжүүлэгч Д.Содномсамбуу нь боловсруулсан арьсаар монгол гутал, гөлөм хийж аймгийн хэрэглэгчдийг хангаж байна.

Мод модон эдлэлийн үйлдвэрийн салбарт иргэн Б.Эрдэнэбат нь гэрийн болон оффисын бүхий л төрлийн тавилга үйлдвэрлэж, дотоодын зах зээлд нийлүүлж байна.

БҮЛЭГ 3. ӨМНӨХ АУДИТААР ӨГСӨН ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ ХАНГАЛТГҮЙ БАЙНА.

ӨМНӨХ АУДИТААР ӨГСӨН ЗӨВЛӨМЖИЙГ ХЭРЭГЖҮҮЛЖ АЖИЛЛААГҮЙ БАЙНА.

3.1. “Жижиг дунд үйлдвэрийг дэмжих сангийн зээлийн хуваарилалт, үр дүн”-д 2018 онд хийсэн гүйцэтгэлийн аудитаар аймгийн ХХААГ-ын даргад 2 заалт бүхий зөвлөмж өгч, хэрэгжилтийг албан бичгээр ирүүлжээ.

3.2. Ирүүлсэн албан бичигт үндэслэн зөвлөмжийн хэрэгжилтийг давтан шалгахад аймгийн ХХААГ-ын жижиг, дунд үйлдвэрлэл хариуцсан мэргэжилтэн ХХААХҮЯ-д хүргүүлсэн мэдээ тайланг бодит тоонд үндэслэн тайлагнаагүй, өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Өмнөх аудитаар өгөгдсөн зөвлөмж:

№	Зөвлөмжийн утга	Хэрэгжилт
1	Төслийн санхүүжилтийг анх баталсан зориулалтаар төсөлд тусгагдсан үйл ажиллагааны ба хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний дагуу зарцуулж байгаа эсэх, төслийн хэрэгжилт, үр дүн, санхүүжилтийн зарцуулалтанд хяналт тавьж ажиллах, мэдээллийг ЖДҮХС-ын удирдлага болон олон нийтэд улирал тутам нээлттэй мэдээлж байх	Хяналт хийсэн боловч нотлох баримт байхгүй байна.
2	Төсөл хэрэгжүүлэгч нарт хүргүүлсэн төслийн хэрэгжилтийн тайланг улирал бүр төлөвлөсөн үр дүн ба бодит үр дүнгээр харьцуулан гаргаж тайлагнах, төсөлд тусгасан ажлын байрыг шинээр бий болгосон тохиолдолд хуулийн дагуу ажилтны НДШ, ХХОАТ-ыг төсөвт төлж баримтжуулсан байх, үйлдвэрлэл нэмэгдэж борлуулалтын орлого, цэвэр ашиг нэмэгдсэн болохыг нотлох баримт болгож албан татварын тайланг улирал бүр гаргаж хэвших, үр дүнгийн биелэлтийн талаар улирал бүр харьцуулсан судалгаа тэмдэглэл гаргаж хэвшин ХХААГ-т ирүүлж, хяналт тавьж ажиллах	Төсөл хэрэгжүүлэгч нараас төслийн хэрэгжилтийн тайланг гаргуулан аваагүй, хяналт хийсэн нотлох баримтгүй байна.

Тухайлбал: 2019 онд ЖДҮХС-аас олгосон зээлд хамрагдсан иргэн, ААН-ийн үйл ажиллагаанд хяналт тавьж зөвлөмж өгч ажилласан гэх боловч нотлох баримтгүй, төсөл хэрэгжүүлэгч нараас хэрэгжилтийн тайланг авч үнэлж, дүгнээгүйгээс хяналт хийсэн эсэх нь нотлогдохгүй байна. Мөн ажлын байр нэмэгдүүлсэн байдалд хяналт тавьж ажилласан нотлох баримтгүй, ХХААХҮЯ-д хүргүүлсэн тайланг зөрүүтэй, бодит тоон мэдээнд үндэслээгүй гаргасан байна.

- Иймд өмнөх зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах хугацаатай албан шаардлагыг хүргүүлээ.

ТӨСӨЛД ХАМРАГДСАН ИРГЭН, ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ЗЭЭЛ АШИГЛАЛТЫН БАЙДАЛД АЙМГИЙН ХХААГ-ААС ХЯНАЛТ ХЭРЭГЖҮҮЛСЭН ЭСЭХ НЬ ТОДОРХОЙГҮЙ БАЙНА.

3.3. ХААН банкаар дамжуулан ЖДҮХС-аас зээл авсан 20 зээлдэгчийн үйл ажиллагаанд хариуцсан зээлийн мэргэжилтэн нар 2019 оны 11 дүгээр сард хяналт тавьсан, мөн ХААН банкны төв салбараас ЖДХҮАҮ хариуцсан албан тушаалтан 2020 оны 03 дугаар сард ЖДҮХС-аас зээл авсан зээлдэгчдийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажилласан байна.

3.4. Аймгийн ХХААГ-аас зээлдэгч нарын үйл ажиллагаа, зээлийн зарцуулалт, ажлын байр нэмэгдүүлсэн байдалд хяналт тавьсан гэх боловч баримтаар нотлогдохгүй байна. Иймд ЖДҮХС-аас олгосон зээлийн ашиглалт, ажлын байр нэмэгдүүлсэн байдалд арилжааны

банктай хамтран хяналт тавьж, бодит тоонд үндэслэн мэдээ тайлан гаргаж, холбогдох газруудад хүргүүлж байх зөвлөмжийг аймгийн ХХААГ-т хүргүүлэв.

ЖДҮХСангаас 2019, 2020 онд зээл авсан иргэн, ААН-ийн хаяг байршлийн судалгаа:

Хавсралт 1

Д/д	Төсөл, арга хэмжээний нэр	Хүссэн санхүүжилт	Зээлийн зориулалт	Санхүүжүүлсэн дүн	Хаяг, байршил
1	Уламбаяжихуй ХХК "Өдөр бүр-Шинэ хүнс" төсөл /2019 он/	200,000,000	Үйлдвэрийн барилга барих	200,000,000	Эрдэнэбулган сум
2	Баялаг заваг ХХК "Баялаг заваг" төсөл /2019 он/	140,000,000	Үйлдвэрийн байр барих, тоног төхөөрөмж худалдан авах	120,000,000	Эрдэнэбулган сум
3	Наймган тал Дэйри ХХК "Цагаан идээний бүрэн автомат үйлдвэр байгуулах" төсөл /2019 он/	150,000,000	ажлын байраа өргөжүүлэх тоног төхөөрөмж худалдан авах	120,000,000	Эрдэнэбулган сум
4	"Ар арвижин дэлгэрэх" хоршоо "Сарлагын хөөврөн сүлжмэл бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг хөгжүүлэх" төсөл /2019 он/	128,000,000	Үйлдвэрлэлээ өргөжүүлэх тоног төхөөрөмж, түүхий эд материал худалдан авах	62,000,000	Эрдэнэбулган сум
5	О.Алтангэрэл "Уламжлалт ааруул цөрөм үйлдвэрлэх" төсөл /2019 он/	80,000,000	Тоног төхөөрөмж худалдан авах	40,000,000	Эрдэнэбулган сум
6	Б.Эрдэнэбат "Содон шийдэл тавилга үйлдвэрийн" төсөл /2019 он/	49,000,000	Үйлдвэрээ өргөжүүлэх, тоног төхөөрөмж, түүхий эд материал худалдан авах	35,000,000	Эрдэнэбулган сум
7	"Хөл саяын хишиг" ХХК "Амтат ааруул" төсөл /2019 он/	60,000,000	ажлын байр нэмэгдүүлэх, тоног төхөөрөмжөө шинэчлэх	35,000,000	Эрдэнэбулган сум
8	Б.Янжинлхам "Өдөр тутмын болон гоёлын хувцас үйлдвэрлэл" төсөл /2019 он/	60,000,000	Үйлдвэрлэлээ өргөжүүлэх тоног төхөөрөмж, түүхий эд материал худалдан авах	30,000,000	Эрдэнэбулган сум
9	Д.Содномсамбуу "Монгол гутал, гөлөм" төсөл /2019 он/	52,500,000	Үйлдвэрийн байрны засвар тохижилт хийх, тоног төхөөрөмж, түүхий эд материал худалдан авах	25,000,000	Эрдэнэбулган сум
10	Д.Пүрэвжав "Авто засвар" төсөл /2019 он/	30,000,000	Тоног төхөөрөмж худалдан авах	20,000,000	Эрдэнэбулган сум
11	Хангайн ногоон мандал ХХК "Архангайн ургац" төсөл /2019 он/	35,000,000	Тоног төхөөрөмж худалдан авах	20,000,000	Эрдэнэбулган сум
12	Г.Гэрэлбат "Төмөр хийц" төсөл /2019 он/	30,000,000	Үйлдвэрлэлээ өргөжүүлэх тоног төхөөрөмж, түүхий эд материал худалдан авах	20,000,000	Эрдэнэбулган сум
13	Д.Ганхуяг "Арвин сүрэг" төсөл /2019 он/	30,000,000	Тоног төхөөрөмж худалдан авах	20,000,000	Хашаат сум
14	С.Гончигдорж "Эко ааруул сүү, сүүн бүтээгдэхүүн боловсруулах" төсөл /2019 он/	45,000,000	ажлын байраа өргөжүүлэх тоног төхөөрөмж худалдан авах	20,000,000	Тариат сум

15	Уран дөш саруул ХХК "Зам дагаж хөгжих төсөл /2019 он/	100,000,000	Тоног төхөөрөмж худалдан авах	83,000,000	Өлзийт сум
16	"Цэлмэг орхон" хоршоо "Хүнсний ногоо тариалж даршлах, хадгалах" төсөл /2019 он/	60,000,000	Зоорь барих ногоо даршлах тоног төхөөрөмж	40,000,000	Өлзийт сум
17	Цоросын ач хоршоо "Арьс нэхий сур суран эдлэлийн үйлдвэр" төсөл /2019 он/	42,000,000	ажлын байр барих, агуулах барих, гүний худагтай болох, түүхий эд худалдан авч нөөцлөх, халаалт тавиулах	20,000,000	Өлзийт сум
18	Тайхар милко ХХК "Эко бүтээгдэхүүн ба эрүүл хүүхэд гэр бүл" төсөл /2019 он/	103,660,000	фермерийн үйл ажиллагааг өргөжүүлэн үйлдвэрлэлийн байр шинээр барих	50,000,000	Ихтамир сум
19	Л.Түвшинтөр "Ган хийц" төсөл /2019 он/	35,000,000	Үйлдвэрлэлээ өргөжүүлэх тоног төхөөрөмж, түүхий эд материал худалдан авах	20,000,000	Жаргалант сум
20	Зуслан гурван ган хоршоо "Жимс жимсгэнэ боловсруулах үйлдвэр" төсөл /2019 он/	67,000,000	жимсний төрөлжсөн үйлдвэрийг бий болгох	20,000,000	Жаргалант сум
21	Арвин үр шим ХХК "Төмс хүнсний ногоо" / Эрдэнэбулган сум/ /2020 он/		Зоорь барих	60,000,000	Эрдэнэбулган сум
22	Арвижих цэнхэр ХХК "Аялал жуулчлал" төсөл /Цэнхэр сум/ /2020 он/	290,000,000	Үйлчилгээний барилга, Хашаа барих, ариун цэврийн барилга гүний худаг, шинэ гэр барих	200,000,000	Цэнхэр сум
23	Зургаан эгшиг ХХК "Аялал жуулчлал" төсөл /Цэнхэр сум/ /2020 он/	200,000,000	өвлийн амралтын тохижилт, /цомцог гэр/ цэвэр бохирын шугам тавих	100,000,000	Цэнхэр сум
24	Баянзүрх оргилжин мөнх ХХК "Эко хүнс" төсөл /2020 он/	60,000,000	Ажлын байр өргөжүүлэх тоног төхөөрөмж авах	40,000,000	Чулуут сум
25	Хан дулаан хан хоршоо "Малын дайвар бүтээгдэхүүн үйлдвэрлэл" төсөл /2020 он/	100,000,000	Үйлдвэрийн байр, тоног төхөөрөмж авах, ажлын байр, түүхий эд, сав баглаа боодол	100,000,000	Жаргалант сум
Нийт дүн		2,147,160,000	-	1,500,000,000	

АУДИТЫН ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйл аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг өглөө.

Жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сангийн хөрөнгийг зориулалтын дагуу үр дүнтэй зарцуулсан байна.

- Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгосон төслийн сонгон шалгаруулалтыг журмын дагуу явуулсан байна.
- Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас зээл авсан зээлдэгчид төсөлд заагдсан арга хэмжээг хэрэгжүүлж, зээлийг зориулалтын дагуу зарцуулсан байна.
- Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй байна.

Аудитаар нийт 30.0 сая төгрөгийн зөрчил илрүүлж зөрчлийг арилгах, цаашид давтан гаргахгүй байх 3 албан шаардлага, үйл ажиллагааг сайжруулж, үр нөлөө бий болгож ажиллах 3 зөвлөмжийг холбогдох албан тушаалтнуудад хүргүүлэв.

АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах зөвлөмжийг хүргүүлж байна.

Аймгийн ИТХ-ын дарга Б.Батжаргал танаа

1. Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 15.2."Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь аймаг, нийслэлийн Засаг даргын өргөн мэдүүлсэн Аймаг, нийслэл, хотыг хөгжлүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн төслийг үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын саналыг харгалзан үйлчлэх хугацаанаас зургаан сарын өмнө батална", 18.6."Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөөний төслийг жил бүрийн 12 дугаар сарын 10-ны дотор батална" гэсэн заалтуудын дагуу аймгийг хөгжүүлэх тэргүүлэх чиглэлийг баталж ажиллах

Аймгийн ХХААГ-ын дарга П.Гомбодорж танаа

1. Хөнгөлөлттэй зээл олгох шийдвэрийг гаргахад оролцох эрх бүхий этгээд нь ашиг сонирхлын зөрчлөөс ангид байж, нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасан мэдэгдэл, тайлбарыг тухай бүр гаргаж хэвших
2. ЖДҮХС-аас олгосон зээлийн ашиглалт, ажлын байр нэмэгдүүлсэн байдалд тавих холбогдох мэргэжилтний хяналтыг сайжруулж, зээлдэгч нараас хэрэгжилтийн тайланг авч бодит тоон мэдээнд үндэслэн мэдээлж байх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Архангай аймаг дахь Төрийн аудитын байгууллагад 2021 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ:



АРХАНГАЙ АЙМГИЙН
ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗАР

65141 Архангай аймаг, Эрдэнэбулган сум, 1 дүгээр баг,
Утас/Факс: (976) 7033 3889,
И-мэйл: arxxaagazar@gmail.com

2021.10.20 № 01/482
танай 2021.10.15 -ны № 363 -Т

Тайлбар хүргүүлэх тухай

АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Аудитор Н. Энхтүвшин
Энгийнхэн суусан
арга хэмтэй авч
амжилсан.
Н. Энхтүвшин
2021

Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн 2019-2020 оны зээлийн үр дүн, эргэн төлөлтийн байдалд хийсэн аудитын тайлантай танилцлаа. Тайланд дурдагдсан зарим зүйлд тайлбар хүргүүлж байна. Үүнд:

1. 2019, 2020 онуудад нийт 25 иргэн, аж ахуйн нэгжид 1,5 тэрбум төгрөгийн зээлийг Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас батлагдсан журмын дагуу олгосон. Сүүлийн 2 жилийн хугацаанд улс орон даяар тархсан цар тахлын нөхцөл байдлын улмаас удаа дараа хөл хорио тогтоож, үйл ажиллагааг зогсоох хүртэл арга хэмжээ авч ажилласан нь иргэн, аж ахуйн нэгжүүдийн тогтвортой үйл ажиллагаа явуулахад нөлөөлж, ажлын байраа хадгалах, нэмэгдүүлэхэд хүндрэл учруулсан.

2. Зээл олгосноос хойш манай байгууллагын асуудал хариуцсан мэргэжилтнүүд зээлийн ашиглалт, үр дүнд хяналт шалгалтыг тогтмол хийж ажилласан болно. Жижиг дунд үйлдвэрлэлийн асуудал хариуцсан мэргэжилтэн нь уг зээлийн ашиглалтад хяналт тавих тусгайлсан зардалгүй бөгөөд байгууллагын цаг үеийн ажлаар сумдад ажиллах ажлын хэсэгт орж орон нутагт ажиллах үеэрээ зээл авсан иргэн, аж ахуйн нэгжтэй байнга уулзаж мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, санал бодлыг нь сонсож ажилласан болно.

Холбогдох баримтыг хавсралтаар хүргүүлэв.

Хавсралт 4 хуудастай

ДАРГА

П.ГОМБОДОРЖ

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛД ӨГСӨН ТАЙЛБАР:

ХХААГ-ын 2021 оны 10 дугаар сарын 20-ны 01/422 тоот албан бичгээр ирүүлсэн саналд өгсөн тайлбар:

1. Аудитаас Ковид-19 цар тахалтай холбоотойгоор төсөлд тусгагдсан ажлын байрыг төлөвлөсөн хэмжээндээ нэмэгдүүлээгүй байгааг харгалзан үзсэн. Гэхдээ Засгийн газрын 2020 оны 113 дугаар тогтоолоор батлагдсан “Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, дамжуулан зээлдүүлэх, эргэн төлүүлэх, хяналт тавих журам”-д заасны дагуу хяналт тавьж ажиллах нь зүйтэй байна. Иймээс аудитын тайланд өөрчлөлт ороогүй болно.
2. ХХААГ-аас албан томилолтоор ажилласан баримтыг ирүүлсэн, мөн аудитын явцад ирүүлсэн уг тайланд жилд 3 удаа сумдаар тойрч хяналт тавьж ажилласан гэх боловч тухайн ажлын тайланд төсөл хэрэгжүүлэгч нарт өгсөн зөвлөмжийг тусгаагүй, төсөл хэрэгжүүлэгч нараас зөвлөмжийн биелэлтийг аваагүй байгаа нь “Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, дамжуулан зээлдүүлэх, эргэн төлүүлэх, хяналт тавих журам”-ын 16.1.1, 16.2 дахь заалтуудын дагуу хяналт тавьж ажилласан нь нотлогдохгүй байна. Иймээс аудитын тайланд өөрчлөлт ороогүй болно.

ТАЙЛАН БАТАЛСАН ТУШААЛ:

АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ТУШААЛ

2021 оны 10 сарын 21 өдөр

Дугаар А/31

Цэцэрлэг

Гүйцэтгэлийн аудитын тайлан
баталгаажуулах тухай

Монгол улсын Ерөнхий аудиторов 2018 оны а/207 тушаалын 5 дугаар хавсралтын 1.3, 2.4 дахь заалт, 2021 оны 06 дугаар сарын 18-ны өдрийн А/69 дугаар тушаалын хавсралт "Гүйцэтгэлийн аудитын заавар, аргачлал", Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын 2021 оны 10 сарын 21-ний өдрийн Удирдлагын зөвлөлийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сангийн 2019-2020 оны зээлийн үр дүн, эргэн төлөлтийн байдал"-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг баталгаажуулсугай.

2. Аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийг хавсралтаар баталгаажуулсугай.

3. Аудитын тайланг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал, аймгийн Засаг дарга, Хүнс хөдөө аж ахуйн газарт тус тус хүргүүлсүгэй.

4. Гүйцэтгэлийн аудитын тайланд тусгагдсан зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Гүйцэтгэлийн аудитын багийн ахлах аудитор (Х.Алтанчимэг)-т даалгасугай.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Т.БАЙГАЛМАА

Дарга, тэргүүлэх аудиторовын
2021 оны 10 дугаар сарын 11 өдрийн
131 тоот тушаалын хавсралт

№	Хүргэгдэх байгууллага	Албан шаардлага		Зөвлөмж Тоо	Хариуцах албан тушаалтан
		Тоо	Дүн		
1	Аймгийн ИТХ			1	Хурлын дарга Б.Батжаргал
2	ХХААГ	3		2	ХХААГ-ын дарга П.Гомбодорж, Мэргэжилтэн Ц.Санжидмолон



АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 10 сарын 22 өдөр

Дугаар 165/А0370218

Цэцэрлэг

АРА - 2021/50 - ШТА - ГА

ЗӨРЧИЛ АРИЛГУУЛАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 9 дүгээр зүйлийн 9.1 дэхь заалтын дагуу Төрийн аудитын газрын 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө, "Аудитын төлөвлөгөө батлах тухай" Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2021 оны А/28 дугаар тушаалын дагуу "Архангай аймгийн жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн 2019-2020 оны зээлийн үр дүн, эргэн төлөлтийн байдал"-д хийсэн гүйцэтгэлийн аудитаар төсөл хэрэгжүүлэгч "Наймган тал Дэйри" ХХК нь ХААН банкинд зээл хойшлуулах хүсэлт өгсөн хэдий ч зээл хойшлуулах шийдвэр ирээгүй байхад зээлийг хуваарийн дагуу төлөөгүй зөрчил илэрлээ.

Энэ нь Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуулийн 13.2.8 "Сангаас олгосон хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулах, зээлийн гэрээний үүргээ биелүүлэх", Засгийн газрын 2020 оны 113 дугаар тогтоолын жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, дамжуулан зээлдүүлэх, эргэн төлүүлэх, хяналт тавих журмын 15.1. "Жижиг, дунд үйлдвэрийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага зээлдэгчтэй байгуулсан зээлийн гэрээ, эргэн төлөлтийн хуваарийн дагуу зээлийн эргэн төлөлт, зээлийн хүү, алдангийг тухай бүр төлүүлнэ" гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны 12 дугаар сарын 09-ны өдрийн А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэсэн заалтыг тус тус үндэслэн ШААРДАХ нь:

1. "Наймган тал Дэйри" ХХК-ний зээлийг хуваарийн дагуу төлүүлэх талаар холбогдох арга хэмжээг авч зөрчлийг арилган биелэлтийг 2021 оны 12 дугаар сарын 25-ны дотор ирүүлэх
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг аймгийн ХХААГ-ын дарга П.Гомбодорж, жижиг, дунд үйлдвэрлэл хариуцсан мэргэжилтэн Ц.Санжидмоллом нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТОР:

П.ЭНХЖАРГАЛ



000043071

АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 10 сарын 22 өдөр

Дугаар 166/АДЗТДЗ18
АРА-2021/50-ШТА-ГА Цэцэрлэг

ЗӨРЧИЛ АРИЛГУУЛАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 9 дүгээр зүйлийн 9.1 дэхь заалтын дагуу Төрийн аудитын газрын 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө, "Аудитын төлөвлөгөө батлах тухай" Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2021 оны А/28 дугаар тушаалын дагуу "Архангай аймгийн жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн 2019-2020 оны зээлийн үр дүн, эргэн төлөлтийн байдал"-д гүйцэтгэлийн аудит хийхэд өмнөх аудитаар өгсөн дараах зөвлөмжийг хэрэгжүүлээгүй зөрчил илэрлээ. Үүнд:

1. Төслийн санхүүжилтийг анх баталсан зориулалтаар төсөлд тусгагдсан үйл ажиллагааны ба хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний дагуу зарцуулж байгаа эсэх, төслийн хэрэгжилт, үр дүн, санхүүжилтийн зарцуулалтанд хяналт тавьж ажиллах, мэдээллийг ЖДҮХСангийн удирдлага болон олон нийтэд улирал тутам нээлттэй мэдээлж байх
2. Төсөл хэрэгжүүлэгч нарт хүргүүлсэн төслийн хэрэгжилтийн тайланг улирал бүр төлөвлөсөн үр дүн ба бодит үр дүнгээр харьцуулан гаргаж тайлагнах, төсөлд тусгасан ажлын байрыг шинээр бий болгосон тохиолдолд хуулийн дагуу ажилтны НДШ, ХХОАТ-ыг төсөвт төлж баримтжуулсан байх, үйлдвэрлэл нэмэгдэж борлуулалтын орлого, цэвэр ашиг нэмэгдсэн болохыг нотлох баримт болгож албан татварын тайланг улирал бүр гаргаж хэвших, үр дүнгийн биелэлтийн талаар улирал бүр харьцуулсан судалгаа тэмдэглэл гаргаж хэвшин ХХААГ-т ирүүлж, хяналт тавьж ажиллах

Энэ нь Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны 12 дугаар сарын 09-ны өдрийн А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.4.1.6-д "Аудитаар илэрсэн зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй", Төрийн аудитын газраас 2018 онд "Архангай аймгийн ХХААГ-ын жижиг дунд үйлдвэрийг дэмжих сангийн 2016-2017 оны хөрөнгийн зарцуулалт үр дүн"-д хийсэн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлтийг хэрэгжүүлээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны 12 дугаар сарын 09-ны өдрийн А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.4.1.6-д "Аудитаар илэрсэн зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол" гэсэн заалтуудыг үндэслэн ШААРДАХ нь:

003043375

1. Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө гарган биелэлтийг 2021 оны 12 дугаар сарын 25-ний дотор ирүүлэх
2. Цаашид хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг аймгийн ХХААГ-ын дарга П.Гомбодорж, жижиг, дунд үйлдвэрлэл хариуцсан мэргэжилтэн Ц.Санжидмолон нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:
АУДИТОР:  П.ЭНХЖАРГАЛ





АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 10 сарын 22 өдөр

Дугаар

167/А0370218

Цэцэрлэг

АРА-2021/50-ШТА-ГА

ЗӨРЧИЛ АРИЛГУУЛАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 9 дүгээр зүйлийн 9.1 дэхь заалтын дагуу Төрийн аудитын газрын 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө, "Аудитын төлөвлөгөө батлах тухай" Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2021 оны А/28 дугаар тушаалын дагуу "Архангай аймгийн жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн 2019-2020 оны зээлийн үр дүн, эргэн төлөлтийн байдал"-д гүйцэтгэлийн аудит хийхэд 30.0 сая төгрөгийн зөрчил илэрлээ. Үүнд:

"Өдөр тутмын болон гоёлын хувцас үйлдвэрлэл" төсөл хэрэгжүүлэхээр зээл авсан иргэн Б.Янжинлхамд "аймгийнхаа хэрэглэгчдэд импортыг орлох, эх орондоо үйлдвэрлэсэн гоёлын болон өдөр тутмын, чанартай материал хийцтэй, загварлаг боломжийн үнэтэй хувцасыг санал болгох, урлангаа брэнд болгон хөгжүүлэх зориулалтаар олгосон 30.0 сая төгрөгийн зээл нь зээлийн гэрээнд тусгагдсан зорилгоо биелүүлээгүй орон нутагт үйл ажиллагаа явуулаагүй, төлөвлөсөн ажлын байрыг бий болгосон нь тодорхойгүй, аймгийн ХХААГ-аас төслийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллаагүй байна.

Энэ нь Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуулийн 8.1-д "Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээний цар хүрээ, хөгжлийн үе шат, бүс нутгийн хөгжилд үзүүлэх нөлөө, гадаад зах зээлд нэвтрэх чадамж, техник, технологийн байдлыг нь харгалзан төрөөс дараах чиглэлийн дэмжлэгийг үзүүлнэ", 8.1.9."кластерын хэлбэрээр үйл ажиллагаа явуулдаг жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчийг тухайн орон нутаг дахь түүхий эдийн болон ажиллах хүчний нөөц, чадавх бусад онцлогоос хамааран дэмжих", 13.2.8-д "Сангаас олгосон хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулах, зээлийн гэрээний үүргээ биелүүлэх", Засгийн газрын 2020 оны 113 дугаар тогтоолын жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, дамжуулан зээлдүүлэх, эргэн төлүүлэх, хяналт тавих журмын 16.2-д "Жижиг, дунд үйлдвэрийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага жилд нэгээс доошгүй удаа зээлийг зориулалтын дагуу зарцуулж байгаа эсэхэд иж бүрэн эсхүл түүвэрчилэн хяналт, шалгалт хийнэ. Хяналт, шалгалтын дүнг тухай бүр нэгтгэн жижиг, дунд үйлдвэрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ" гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны 12 дугаар сарын 09-ны өдрийн А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан

000040009

гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэсэн заалтыг тус тус үндэслэн ШААРДАХ нь:

1. Илэрсэн алдаа зөрчлийг таслан зогсоож, "Өдөр тутмын болон гоёлын хувцас үйлдвэрлэл"-ийн төслийн хэрэгжилт, зээлийг зориулалтын дагуу зарцуулж буй эсэхэд хяналт шалгалт хийн холбогдох арга хэмжээг авах замаар аудитаар илэрсэн зөрчлийг арилгаж биелэлтийг 2021 оны 12 дугаар сарын 25-ны дотор ирүүлэх
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг аймгийн ХХААГ-ын дарга П.Гомбодорж, жижиг, дунд үйлдвэрлэл хариуцсан мэргэжилтэн Ц.Санжидмолон нарт даалгав.

